

Аюулгүй ажиллагааны дүрэм

Аюулгүй ажиллагааны дүрэм гэдэг нь хувь хүн, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг болзошгүй аюул, осол, гэмтлээс хамгаалахад чиглэсэн тогтоосон заавар, дүрэм, зарчмуудыг хэлнэ. Ажлын байр, сургууль, лаборатори, олон нийтийн газар гэх мэт янз бүрийн орчинд эрсдэлийг бууруулах, аюулгүй, хариуцлагатай зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор эдгээр дүрмийг мөрддөг. Аюулгүй ажиллагааны дүрэм нь осол, гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай бөгөөд ихэвчлэн тоног, төхөөрөмж, машин механизм ашиглах, аюултай материалтай харьцах, галын аюулгүй байдал, замын хөдөлгөөний дүрэм гэх мэт олон төрлийн үйл ажиллагаа, нөхцөл байдлыг хамардаг. Аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөх нь хувь хүмүүсийн сайн сайхан байдал, олон нийт, байгууллагын аюулгүй байдлыг хангахад маш чухал юм.

Бага ангийн байгалийн ухааны туршилтат хичээл дээр баримтлах аюулгүй ажиллагааны дүрэм нь байгалийн ухааны хичээлийн туршилт гүйцэтгэх явцад бага насны сурагч, багш нарын аюулгүй байдлыг хангах, багаж, төхөөрөмжийг эвдэрч, гэмтэхээс сэргийлэх тусгай заавар, зарчим юм. Эдгээр дүрмүүд нь осол, гэмтэл, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ бага насны сурагчдад аюулгүй, боловсролын орчныг бүрдүүлэхэд чиглэгдэж байдаг. Бага ангийн байгалийн ухааны хичээлийн аюулгүй ажиллагааны дүрэмд ихэвчлэн материал, тоног төхөөрөмж, химийн бодис, болзошгүй аюултай нөхцөл байдалтай хэрхэн харьцах тухай зааврыг багтаадаг. Энэ нь бага сургуулийн сурагчдад заавар, зөвлөмжийг уншиж, түүнийг дагаж мөрдөх, багаж, төхөөрөмжтэй зөв ажиллах, гэх мэт хариуцлагатай зан үйлийг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй юм.

Туршилтын төрөл, ашигласан материалаас хамааран баримтлах аюулгүй ажиллагааны дүрэм нь өөр өөр байдаг. Ихэнх шинжлэх ухааны туршилтуудад хэрэглэгдэх аюулгүй ажиллагааны ерөнхий дүрэмтэй танилцъя:

1. Хамгаалалтын хэрэгслийг үргэлж өмсөх:

- Туршилтын төрлөөс хамааран нүдний шил, бээлий, амны хаалт, хормогч эсвэл лабораторийн халаад гэх мэт хамгаалалтын хэрэгслийг өмсөх.



- Химийн бодис, эсвэл халуун ус цацахаас нүдээ хамгаалахын тулд хамгаалалтын шил зүүх.
- Хувцас дээр бодис асгарч толбо үүсэхээс хамгаалахын тулд хормогч эсвэл лабораторийн халаад өмсөх.

2. Удирдамж, зааврыг баримтлах:

- Туршилтыг эхлэхээсээ өмнө зааврыг анхааралтай уншиж, ойлгох.
- Тодорхой бус, ойлгомжгүй зүйл байвал тодруулж асуух.
- Лабораторийн тоног төхөөрөмжтэй болгоомжтой харьц. Зөвхөн багшийн өгсөн эсвэл зөвшөөрсөн тоног төхөөрөмжийг ашиглах.
- Өгөгдсөн алхмуудыг дагаж ямар ч алхмыг алгасах эсвэл хяналтгүйгээр бие даан туршилт хийхийг бүү оролд.

3. Идэж, уухгүй байх:

- Химийн бодисыг санамсаргүйгээр уухаас зайлсхийхийн тулд лабораторид юм идэж, ууж, бохь зажилж болохгүй.
- Хоол хүнс, ундааг туршилт хийж буй ширээнээс хол байлгах.



4. Химийн бодистой аюулгүй харьцах:

- Зөвхөн багшийн зөвшөөрсөн химийн бодис, материалыг ашиглах.
- Туршилтад заасан хэмжээгээр бодис хэрэглэнэ. Шаардлагатай хэмжээнээс илүү хэрэглэж болохгүй.
- Бодисыг хэзээ ч үнэрлэж, амталж, гараар барьж болохгүй. Тохиромжтой багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үргэлж ашиглах.

5. Тоног төхөөрөмжийг зөв ашиглах:

- Тоног төхөөрөмжийг зөвхөн зааврын дагуу ашигла. Лабораторийн багаж хэрэгслийг буруугаар ашиглах, тоглож болохгүй.
- Хэрэв та ямар нэг төхөөрөмжийг хэрхэн ашиглахаа мэдэхгүй байгаа бол багшаас тусламж хүсэх.
- Хурц иртэй зүйлтэй (хайч, хусуур) болгоомжтой харьцаж, үргэлж өөрөөсөө болон бусдаас холдуулах.

6. Дулааны эх үүсвэр ашиглах:

- Халаах зуух эсвэл спиртэн дэнг зөвхөн насанд хүрэгчдийн хяналт дор хэрэглэх
- Халуун объекттой харьцахдаа халуунд тэсвэртэй бээлий хэрэглэх

7. Цэвэрлэх:

- Туршилтын дараа тоног, төхөөрөмжөө цэгцлээрэй. Асгарсан зүйлийг нэн даруй цэвэрлэ. Багшийн зааврын дагуу материалыг зохих ёсоор хаяж, устгах.
- Бодис, лабораторийн тоног төхөөрөмжтэй харьцсаны дараа гараа сайтар угаах.

8. Ослын талаар мэдээлэх:

- Осол гарсан тохиолдолд бүү сандар.
- Ямар нэгэн осол, асгарсан, эвдэрсэн тоног төхөөрөмжийн талаар хэчнээн жижиг мэт санагдаж байсан ч тэр даруй багшид мэдэгдэх.

9. Багаж, тоног төхөөрөмжтэй ангид:

- Шилэн сав, туршилтын багажтай болгоомжтой харьц. Шилэн сав хагарвал багшид нэн даруй мэдэгдэнэ. Үүнийг өөрөө цэвэрлэх гэж бүү оролдоорой.
- Лабораторийн өрөө, багаж төхөөрөмжтэй ангид гүйж, харайх, хөөцөлдөж тоглох зэрэг осолд хүргэж болзошгүй аливаа үйлдлийг бүү хий.
- Бусдын туршилтад бүү саад болоорой.

10. Онцгой нөхцөл байдлын журам:

- Гал унтраагч, угаалтуур, анхны тусламжийн хэрэгсэл зэрэг аюулгүй байдлын тоног төхөөрөмжийн байршлыг мэдэх.



- Онцгой нөхцөл байдлын үед нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө болон зориулалтын цугларалтын газрыг мэдэх.



Байгалийн ухааны туршилтад хичээл дээр анхаарах зүйлс

Байгалийн ухааны хичээл дээр ихэвчлэн туршилт явуулах шаардлага гардаг. Тухайлбал тухайн хичээлд спиртэн дэн хэрэглэх үед дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

1. Спиртэн дэн ямар байх вэ? Спиртэн дэнгийн хөвөн гол доорх зурагт үзүүлсэн шиг байх хэрэгтэй. Хэрэв хэтэрхий богино буюу урт байвал гал алдах аюултай. Богино бол



шилэн дотор гал унана, урт байвал гал нь гадагшаа унаж болзошгүй.

2. Туршилтын ширээн дээр гал авалцаж болзошгүй цаас зэргийг тавьж болохгүй. Мөн охид үсээ задгай тавихгүй буюу зориулалтын малгай өмсөхгүй бол үсээ заавал хумьж боосон байх шаардлагатай.

3. Спиртэн дэнгийн хөвөнгийн ил гарах үзүүр буюу асаах хэсэг нь 5мм орчим байна. /зурагт

үзүүлснээр /

4. Чүдэнзийг зураад хэрэглэсний дараа зуруулыг төмөр саванд хийнэ. Багш туршилтын хичээл дээр чүдэнз хэрэглэхээр төлөвлөсөн бол зуруул хийх жижиг төмөр сав бэлтгэсэн байх шаардлагатай.



5. Спиртэн дэнг заавал тусгай төмөр сав буюу төмөр суурин дээр байрлуулна.



6. Асаж байгаа спиртэн дэнгээс нөгөө спиртэн дэнг асааж болохгүй. Учир нь спиртэн дэнгийн спирт савыг онгойлгох үед асгарч гал авалцах аюултай.

7. Байгалийн ухааны туршилтат хичээлийн үед бодис болон бусад зүйлс хүүхдийн нүд рүү үсрэх эрсдэл бүхий туршилт хийх үед

хамгаалалтын нүдний шил зүүлгэх хэрэгтэй.